



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН “СҮЛД”
БИЕИЙН ТАМИР СПОРТ ХОРООНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/249/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Э.Бүгүнүтэй
Утас: 261456 Цахим хаяг: bugunuteie@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Акпар Аудит ХХК
Захирал: Х. Баянбай
Утас: 91919758 Цахим хаяг: akpar.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Албан шаардлага.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН “СҮЛД” БИЕИЙН
ТАМИР, СПОРТ ХОРООНЫ ДАРГА
Н.БАТСУУРЬ ТАНАА

2022.02.24 № 07/318
танай _____-ны № _____-т
Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир спорт хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир спорт хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй төлөвлөгөөнөөс давсан туслах аж ахуйн орлого 15,315.0 мянган төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төлбөрт шилжүүлж, төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.3-д “Энэ журмын 3.1.2-т заасан төсвийн жилийн дундуур шинээр бий болсон нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж (орон нутгийн төсөвт байгууллага, болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын хувьд орон нутгийн санхүү, төсвийн асуудал хариуцсан нэгжийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн) хүлээн авч хянасны үндсэн дээр тухай бүр нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,373,701.00	30,841,201.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	12,500.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	12,500.00
3121	Төгрөг	-	12,500.00
31211	Төрийн сангийн харилцах	-	12,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,373,701.00	30,828,701.00
351	Түүхий эд материал	19,882,148.00	21,387,148.00
35110	Тусгай зориулалттай материал	19,882,148.00	21,387,148.00
354	Хангамжийн материал	8,491,553.00	9,441,553.00
35410	Бичиг хэргийн материал	250,000.00	250,000.00
35420	Аж ахуйн материал	6,615,650.00	7,565,650.00
35450	Барилгын засварын материал	499,200.00	499,200.00
35470	Бусад хангамжийн материал	1,126,703.00	1,126,703.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	387,594,603.28	383,770,101.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	387,594,603.28	383,770,101.80
392	Биет хөрөнгө	384,299,062.66	381,543,984.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	359,418,700.00	359,418,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,530,744.56)	(59,903,116.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,901,801.00	100,010,717.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,308,785.83)	(25,839,032.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,652,208.03	16,652,208.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,834,115.98)	(8,795,492.22)
393	Биет бус хөрөнгө	3,295,540.62	2,226,117.54
39301	Программ хангамж	4,277,692.17	4,277,692.17
39302	Хуримтлагдсан элэгдэл	(982,151.55)	(2,051,574.63)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	415,968,304.28	414,611,302.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	14,697,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	14,697,500.00
413	Өглөг	-	14,697,500.00
4136	Бусад өглөг	-	14,697,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	14,697,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	415,968,304.28	399,913,802.80
51	Засгийн газрын хувь оролцоо	415,968,304.28	399,913,802.80
512	Хуримтлагдсан үр дүн	415,968,304.28	399,913,802.80
51210	Өмнөх үеийн үр дүн	365,099,755.52	415,968,304.28
51220	Тайлант үеийн үр дүн	50,868,548.76	(16,054,501.48)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	415,968,304.28	414,611,302.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	514,230,309.21	509,819,796.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,865,409.21	26,664,496.74
120	Нийтлэг татварын бус орлого	85,865,409.21	26,664,496.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,865,409.21	26,664,496.74
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,065,700.00	21,895,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	72,799,709.21	4,769,496.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,364,900.00	483,155,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	428,364,900.00	483,155,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	428,364,900.00	483,155,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	463,361,760.45	525,874,298.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,361,760.45	525,874,298.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,105,643.27	525,291,479.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,690,233.73	463,696,031.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,749,259.09	10,440,849.87
2104	Хангамж, бараа материалын зардал	10,070,706.91	7,989,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,129,700.00	2,516,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	926,000.00	3,715,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,539,743.54	36,933,418.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,117.18	582,818.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	567,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,117.18	15,818.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	50,868,548.76	(16,054,501.48)
5	НИЙТ ҮР ДҮН	50,868,548.76	(16,054,501.48)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	365,099,755.52	383,295,852.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			365,099,755.52	365,099,755.52
Тайлант үеийн үр дүн			50,868,548.76	50,868,548.76
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	415,968,304.28	415,968,304.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			415,968,304.28	415,968,304.28
Тайлант үеийн үр дүн			(16,054,501.48)	(16,054,501.48)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	399,913,802.80	399,913,802.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	441,420,482.82	535,062,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,065,700.00	21,907,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,065,700.00	21,907,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,065,700.00	21,895,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,065,700.00	21,895,000.00
120009	Бусад орлого	-	12,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,354,782.82	513,155,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	428,354,782.82	483,155,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	428,354,782.82	483,155,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,420,482.82	505,050,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,420,482.82	505,050,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,174,482.82	489,152,481.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,690,233.69	463,696,031.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,749,259.13	10,440,849.87
2104	Хангамж, бараа материалын зардал	5,114,500.00	7,518,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,918,790.00	3,781,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	926,000.00	3,715,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,775,700.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,000.00	15,897,818.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	567,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,818.74
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,315,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	30,012,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	30,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	30,000,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	30,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(30,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	12,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489,735,300.00	505,034,481.26	(15,299,181.26)	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,735,300.00	505,034,481.26	(15,299,181.26)	100.0

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,168,300.00	504,467,481.26	(15,299,181.26)	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,698,900.00	463,696,031.39	2,868.61	100.0
210101	Үндсэн цалин	302,972,800.00	340,882,523.56	(37,909,723.56)	112.5
210102	Нэмэгдэл	153,070,100.00	122,813,507.83	30,256,592.17	80.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	-	5,544,000.00	-
210104	Урамшуулал	2,112,000.00	-	2,112,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,447,800.00	10,440,849.87	6,950.13	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	10,447,800.00	9,273,920.47	1,173,879.53	88.8
2104	Хангамж, бараа материалын зардал	7,519,600.00	7,518,600.00	1,000.00	100.0
210401	Бичиг хэрэг	390,100.00	390,100.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,404,800.00	2,404,000.00	800.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	124,400.00	124,200.00	200.00	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,600,300.00	4,600,300.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,786,200.00	19,096,200.00	(15,310,000.00)	504.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,270,000.00	16,580,000.00	(15,310,000.00)	1035.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,200.00	16,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,715,800.00	3,715,800.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,440,000.00	1,440,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	275,800.00	275,800.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	567,000.00	567,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	567,000.00	567,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	567,000.00	567,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	489,735,300.00	505,034,481.26	(15,299,181.26)	103.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	483,155,300.00	483,139,481.26	15,818.74	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	483,155,300.00	483,139,481.26	15,818.74	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,580,000.00	21,895,000.00	(15,315,000.00)	332.8
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,580,000.00	21,895,000.00	(15,315,000.00)	332.8
3	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
4	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛ				
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	44	41	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	43	40	-	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир, спорт хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Акпар-Аудит ХХК-ийн захирал Х.Баянбай, аудитор М.Хосбаяр нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Э.Нармандах хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир, спорт хорооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир спорт хороо нь ШШГЕГ-ын албан хаагчдын эрүүл чийрэг, бие бялдрын бэлтгэлжилтийн норматив үзүүлэлтийг дээшлүүлэх, олон нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох, спортоор хичээллэх таатай орчинг бүрдүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг, ШШГЕГ-ын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус хороо нь дотоод аудит, дотоод хяналтын нэгжгүй бөгөөд дотоод хяналтыг ШШГЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар гүйцэтгэдэг байна. 2021 онд хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир, спорт хорооны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 514,230.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 10,284.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	12.5	12.5
Бараа материал	28,373.7	30,828.7	2,455.0
Үндсэн хөрөнгө	387,594.6	383,770.1	(3,824.5)
Нийт хөрөнгө	415,968.3	414,611.3	(1,357.0)
Байгууллагад өгөх өглөг	-	14,697.5	14,697.5
Засгийн газрын оролцоо	415,968.3	399,913.8	(16,054.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	415,968.3	414,611.3	(1,357.0)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл ШШГЕГ-ын даргын 2021 оны А/83 дугаар тушаалаар худалдаж авсан 30,000.0 мянган төгрөгийн студийн техник хэрэгсэл болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2021 оны А-1/2097 дугаартай албан бичиг, ШШГЕГ-ын 2021 оны 06-02/2638 дугаартай албан бичгийн дагуу үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,108.9 мянган төгрөгийн дасгалын тоног төхөөрөмжийн дүнгээр нэмэгдэж, тайлант онд байгуулсан элэгдэл 36,933.4 мянган төгрөгөөр буурч, нийт дүнгээр өмнөх онтой харьцуулахад 3,824.5 мянган төгрөгөөр буурсан.

- Батлагдсан төсвийн дагуу 10,825.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ШШГЕГ-аас 1,660.6 мянган төгрөгийн бараа үнэ төлбөргүй шилжиж ирсэн байна. Бараа материалын үлдэгдэл өмнөх онтой харьцуулахад 2,455.0 мянган төгрөгөөр өссөн.

- Өглөгийн дансны үлдэгдэл оны эцэст ахмадын сангийн харилцахад данс андуурч орсон 12.5 мянган төгрөг болон ШШГЕГ-ын даргын 2021 оны А/83 дугаар тушаалаар студийн тоног төхөөрөмж худалдаж авахад зориулж 2 жилийн хугацаатай авсан зээлийн үлдэгдлээр 14,685.0 мянган төгрөгөөр өссөн.

2021 онд тус хорооны урсгал зардлын санхүүжилт нэмэгдсэнээс тусламж санхүүжилтийн орлого 54,790.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Туслах үйл ажиллагааны орлого нэмэгдсэн боловч үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос буурснаас татварын бус орлого 59,200.9 мянган төгрөгөөр буурсан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг 489,735.3 мянган төгрөгөөр, үүний 483,155.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,580.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тус тус баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 483,139.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 21,895.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 3.3 дахин буюу 15,315.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Урсгал зардлын төсвийн гүйцэтгэл 505,034.5 мянган төгрөг байгаа нь батлагдсан төсвөөс 15,299.2 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулжээ.

Улсын төсвөөс авсан санхүүжилтээс дутуу зарцуулсан 15.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төлөвлөгөөнөөс давсан туслах аж ахуйн орлого болох 15,315.0 мянган төгрөгийг хөгжмийн салааны техник хэрэгсэл бэлтгэхэд санхүүжүүлсэн ШШЕГ-ын 2 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй авсан эх үүсвэрт шилжүүлсэн нь Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй байна.

Батлагдсан нийт төсвийн 474,146.7 мянган төгрөг буюу 96.8 хувь нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	70705	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	489,735.3	505,034.5	(15,299.2)	103.1
1.1	80101	Үйл ажиллагааны зардал	475,445.5	475,429.7	15.8	100.0
1.2	80102	Туслах үйл ажиллагааны зардал	6,580.0	21,895.0	(15,315.0)	332.7
1.3	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	7,142.8	7,142.8	-	100.0
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	567.0	567.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын 100 жилийн ойг угтаж нийт бие бүрэлдэхүүнийг соён гэгээрүүлэх, хорих ангиудад урлагаар үйлчлэх зорилгоор ШШГЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 19-ний А/83 дугаар тушаалаар 2 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр 30,000.0 мянган төгрөгийн хөгжмийн салааны техник хэрэгсэл худалдаж авсан байна. 2021 онд туслах үйл ажиллагаанаас орсон орлогоос 15,315.0 мянган төгрөгийг төлж, оны эцэст 14,685.0 мянган төгрөгийн өртэй гарсан байна.

3.8 Аудитын гол асуудал

ШШГЕГ-ын даргын 2022 оны А/28 дугаар тушаалаар тус хорооны бүтэц, орон тоо, албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн баталж, 2021 онд байсан 45 орон тооноос соёл, олон нийтийн ажиллагаа хариуцсан ажилтан, удирдаач, дуучин зэрэг 7 орон тоог хасаж, 2022 онд 38 орон тоотой ажиллахаар болсон байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 16 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өмнөх онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчил тайлант онд давтагдаж, шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 5,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

ШШГЕГ-ын “Сүлд” Биеийн тамир спорт хорооны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,295.5	1	3,295.5	-	-	100.0
Албан шаардлага	1	-		-	1	-	80.6

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ШШГЕГ-аас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон хөрөнгийн үлдэгдлийг барагдуулах эх үүсвэрийг хууль эрх зүйн хувьд нийцэж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 15,315.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд 2 албан шаардлага өглөө.

Албан шаардлага

1. Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй төлөвлөгөөнөөс давсан 15,315.0 мянган төгрөгийн туслах аж ахуйн орлогыг ШШГЕГ-аас 2 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төлбөрт шилжүүлж, төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дугаар заалт буюу “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.1-т “Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг дараах хугацааны дотор хянан шийдвэрлэнэ”, 4.1.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрт харьяалагдах төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн саналыг нэгтгэн хянаж энэ журмын 5 дугаар зүйлд заасан материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж (цаашид “төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж” гэх)-д 7 дугаар сарын 15 болон 11 дүгээр сарын 10-ны дотор тус тус хүргүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөвлөгөөнөөс давсан орлогыг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгжийн зөвшөөрөлгүй захиран зарцуулдаг зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

2. Өмнөх онд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 151 мэдээнээс 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд уг зөрчлийг давтан 149 мэдээнээс 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ШШГЕГ-ын "Сүлд" Биеийн тамир спорт хороо	АХГ-2022/249/НА-СТА-ТШЗ	Төлөвлөгөөнөөс давсан туслах үйл ажиллагааны орлогыг хэтрүүлэн зарцуулсан	Давсан орлогыг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгжийн зөвшөөрөлгүй захиран зарцуулдаг зөрчлийг арилгах	1	15,315.0						1	15,315.0			
Дүн					1	15,315.0						1	15,315.0			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ШШГЕГ-ын "Сүлд" Биеийн тамир спорт хороо	АХГ-2022/249/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудаст байршуулах 149 мэдээнээс 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	Хариуцлага тооцох	1	-								1	-	
Дүн					1	-								1	-	
Нийт дүн					2	15,315.0						1	15,315.0	1		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 05/АД/50055

Улаанбаатар хот

АХГ-2022/249/4А-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд" Биеийн тамир, спорт хорооны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөв, санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй төлөвлөгөөнөөс давсан туслах үйл ажиллагааны орлого 15,315,000.00 төгрөгийг зарцуулж, төсвийг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 4.1 "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг дараах хугацааны дотор хянан шийдвэрлэнэ", 4.1.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрт харьяалагдах төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн саналыг нэгтгэн хянаж энэ журмын 5 дугаар зүйлд заасан материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж (цаашид "төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж" гэх)-д 7 дугаар сарын 15 болон 11 дүгээр сарын 10-ны дотор тус тус хүргүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөгөөнөөс давсан орлогыг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгжийн зөвшөөрөлгүй захиран зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд" Биеийн тамир, спорт хорооны дарга Н.Батсуурьт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АКПАР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Х.БАЯНБАЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тийрүү-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.0.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-5.Docx

9019120396

901080025



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 03/А0150055
АХГ-2022/249/НА-СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд" Биеийн тамир, спорт хорооны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчил тайлант онд давтагдаж, шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэснийг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд" Биеийн тамир, спорт хорооны дарга Н.Батсуурьт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АКПАР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Х.БАЯНБАЙ

